

**ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ**

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.12, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, Эрчим хүчний зохицуулах хорооны дүрмийн 2 дугаар зүйлийн 2.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

- 1."Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлийг байгуулах, түүний гишүүнийг томилох, чөлөөлөх журам"-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
- 2.Батласан журмыг Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл"-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлүүдэд даалгасугай.
- 3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны "Журам шинэчлэн батлах тухай" 2015 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 245 дугаар тогтоол, "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 2017 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 186 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
- 4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Г.Эрхэмбаяр)-нд даалгасугай.

**ДАРГА А.ТЛЕЙХАН**

ЗОХИЦУУЛАГЧ Э.ТҮВШИНЧЛУУН

ЗОХИЦУУЛАГЧ Б.БАТТУЛГА

ЗОХИЦУУЛАГЧ Э.САМДАН